



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/Н87

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.5-ын "а", Төсвийн тухай хуулийн 14.2.3, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны ээлжит бус XI хуралдааны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Хөгжимт драмын театрын хөгжимчид Говь-Алтай аймагт болох Урлагийн гавьяат зүтгэлтэн Ш.Аюушийн нэрэмжит үндэсний цөөхүүл болон гоцлол хөгжимчдийн уралдаанд оролцоход 1000000 (Нэг сая) төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2. Дээрх 1000000 (Нэг сая) төгрөгийг Засаг дарга дансны Улс, олон улс, тив, дэлхий тэмцээнүүдэд амжилт гаргасан албан хаагчдад урамшуулал олгох зардлаас гаргахыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн Ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Нармандах)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (С.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД